

ᠮᠤᠩᠭᠠᠨ ᠲᠤᠨᠢᠯᠠᠭᠤᠯᠠ ᠲᠤᠨᠢᠯᠠᠭᠤᠯᠠ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

Алтай хот

АГУУЛГА

1. **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**
2. **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ОНЦЛОГ**
3. **БАРИМТАЛСАН БОДЛОГО, ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМ СОРИЛ**

4. **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН**
 - 4.1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил
 - 4.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
 - 4.3. Шилэн дансны хуулийн хэрэгжилт
5. **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР**
 - 5.1 Санхүүгийн тайлангийн аудитын сүүлийн 5 жилийн зөрчлийн судалгаа
 - 5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар давтан гарсан зөрчлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа

Товчилсон үг:

Товчилсон үг	Товчилсон үгийн тайлал
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХТХ	Төрийн хэмнэлийн тухай хууль
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

Хүснэгтийн товъёг

Хүснэгтийн дугаар	Хүснэгтийн нэр
Хүснэгт №1	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа
Хүснэгт №2	Шилэн дансны тухай хуулийн зөрчлийн судалгаа /сая төгрөг/

Дүрслэл товъёг

Дүрслэлийн дугаар	Хавсралтын нэр
Дүрслэл №1	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлт
Дүрслэл №2	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын зөрчлийн судалгаа
Дүрслэл №3	Санхүүгийн тайлангийн залруулга /сая төгрөг/
Дүрслэл №4	ТХТХ-ын зөрчлийн харьцуулалт /сая төгрөг/
Дүрслэл №5	ТХТХ-ын зөрчлийг ангилж харуулбал: /сая төгрөг/
Дүрслэл №6	Шилэн дансны зөрчлийн өмнөх онтой харьцуулсан судалгаа /тоо/


1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудитыг хийж гүйцэтгэхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт, Санхүүгийн аудитын удирдамж-Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын Стандарт 1000-1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 9 аудитор, хувийн аудитын компанийн 6 аудитор нийт 2590 хүн өдөр, 3868 илүү цаг ажилласан тооцоо гарч байна.

Санхүүгийн тайлангийн аудитын танилцуулга-2024



Нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг <https://www.open.audit.mn/> цахим хуудаснаас үзнэ үү.



2. АУДИТЫН ОНЦЛОГ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 8 дугаар сарын 01-ны өдрийн 75 дугаар тушаалаар Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалтад хамрагдах 201 байгууллагын 282 санхүүгийн тайланд аудит хийхээс 106 санхүүгийн тайланд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторрууд, 38 санхүүгийн тайланд хувийн аудитын компаниар гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангаар 138 санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар батлагдсан.

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын онцлогийг дурдвал:

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтох тухай” 241 дүгээр тогтоолыг баталсан.
- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл” аудитад баримтлах ерөнхий стратегийг баталсан.
- ✓ Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 65 дугаар тушаал “Хөтөлбөр батлах тухай” аккурэл суурьт Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан.
- ✓ Аймаг орон нутагт гарсан онцлог шинжтэй ажил гүйлгээ, олон нийтийн анхаарал татсан эрсдэлтэй асуудлуудын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж санхүүгийн тайлангийн арга зүй, салбар бүрийн онцлогийг тусгасан ажлын баримт, нэг төвшинд шийдвэр гаргах тухай аргачлал боловсруулан хийсэн.



3. БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ГОРИМ СОРИЛ

Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан “Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”, Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий, чиглэл”, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”, бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдийг тусгасан нэгж байгууллагын аудитын төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхдээ дараах горим, сорилуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатанд байгууллагаас авсан хөндлөнгийн мэдээлэл, цахим мэдээллийн дундын сан үүсгэн олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэлд тавигдсан мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулалт хийсний үндсэн дээр аудитад ашигласан.
2. Санхүүгийн программд хөтөлсөн анхан шатны бүртгэлийг хураангуй бүртгэл, ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн хөтлөлттэй тулган баталгаажуулалт хийх аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.
3. Тухайн байгууллагын түүвэрлэж үзсэн зардлын хувьд анхан шатны баримтаас зардлын зүйл ангийн дагуу зарцуулсан эсэхийг дансны хуулга, нягтлан бодох бүртгэлийн дүнтэй тулган баталгаажуулсан.
4. Байгууллагын эзэмшил/өмчлөлд байгаа газрын судалгааг сүүлийн 5 жилээр авч, гэрчилгээ, кадастрын зурагтай тулган баталгаажуулах, бие горим сорил хэрэгжүүлсэн.
5. Төсөл хөтөлбөрийн үр дүн, хөрөнгийн бүртгэлд нэмэлт горим сорил хэрэгжүүлсэн.
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг нэг горим сорил болгон хэрэгжүүлсэн.
7. Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулсан.
8. Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянах үндсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлсэн.
9. Аймгийн байгууллагуудын хувьд эрсдэлтэй асуудал түүнд хэрэгжүүлэх горим сорил, илрүүлэлтийг шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг хийж гарын авлага боловсруулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв захирагч бүрээр гүйцэтгэлийн үе шатны ажилбарыг үзэх ажлын баримтыг хийж www.fas.audit.mn болон уламжлалт аргыг ашигласан.



4. АУДИТЫН ДҮН

Үндсэн мэдээлэл

Аудитын дүнгээр Төрийн аудитын газрын хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, шууд захирагчийн 108, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 21, засгийн газрын тусгай сан, төсөл хөтөлбөрийн 2, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 12 нийт 144 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Төрийн аудитын байгууллагад Дарив сумын “Дарив-Эрчим хүч” ААТҮГ, Эрдэнэ сумын “Эрдэнэ-Эрчим хүч” ААТҮГ-ууд нь сумдын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн аудитаар хамруулсан.

Есөнбулаг сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн тайланд 3 өрхийн эрүүл мэндийн төвийн тайлан нэгтгэгдсэн байна.

Хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлээгүй Есөнбулаг сумын ЗДТГ, ИТХ, Орон нутгийг судлах музейн удирдлага, санхүүгийн ажилтан солигдсон шалтгаантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ыг, 2022 оны 10 дугаар тогтоолоор “Гэгээн-нуур” ААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч татан буулгаж хаалтын баланс гаргаагүй байна.

САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР

Аймгийн хэмжээнд нийт 282 санхүүгийн тайлан гарснаас:

- Аудит хийж дүгнэлт өгсөн 144
 - Өөрчлөлтгүй санал дүгнэлт -100
 - Хязгаарлалттай санал дүгнэлт-38
 - Сөрөг санал дүгнэлт -5
 - Дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт-1
- Түүвэрт хамрагдсан 138

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ

Нийт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 53,840.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 36,334.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулсан.

АУДИТЫН ШИЙДВЭР


Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 17,783,2 сая төгрөгийн зөрчлийн 1,199.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,894.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 15 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 3,412.1 сая төгрөгийн зөрчилд 114 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.



Санхүүгийн тайлангийн аудитын мэдээллийг видео, зурагт хуудас байдлаар www.audit.mn цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлсэн.

Говь-Алтай аймагт 201 байгууллага 282 санхүүгийн тайлан гаргадаг.


Дүрслэл № 1: Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлт



Эх сурвалж: Говь Алтай

аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Дүрслэл №2 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын зөрчлийн судалгаа /сая төгрөг/



Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

4.1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ:

Төсвийн захирагчийн эрх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн зарчим, төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар жил бүрийн төсвийн тухай хуульд дэлгэрэнгүй тусган холбогдох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан төсөв баталж хуваарилдаг. Энэхүү батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, үнэн зөв тайлагнах эрх, үүргийг хуулийн хүрээнд төсвийн захирагч хэрэгжүүлдэг.

Санхүүгийн тайлангийн аудитаар тухайн төсвийн захирагчийн гаргасан санхүүгийн тайлан илчлэл толилуулга үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын байгууллага тодорхой горим сорил хэрэгжүүлэн үүсэх магадлалтай эрсдэлийн дүнд үндэслэн түүвэрлэн авч үзэж дүгнэлт гаргадаг.

Хүснэгт №1: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитын нэр	Нийт	өгсөн дүгнэлт					Илрүүлсэн зөрчил	Залруулсан	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хариуцлага тооцсон албан тушаалтан	Зөвлөмж
			Өөрчлөлтийг	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалсан	ан						
1	ТШЗ	108	86	16	5	1	19,108.2	10,880.3	121.8	7,680.8	13.0	425.3	
2	ЗГТС	2	2				2,115.4	1,182.5	457.8	415.6	-	59.5	
3	ТБОНӨХЭ	12	7	5			8,800.9	7,029.3	408.2	1,306.1	2.0	57.3	
4	ТТЗ	21	5	16			11,934.6	10,858.1	208.7	867.8	-		
5	ТЕЗ	1		1			11,881.8	6,384.2	3.4	2,624.2	-	2,870.0	
	Дүн	144	100	38	5	1	53,841.0	36,334.4	1,199.9	12,894.6	15	3,412.1	


Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Илэрсэн нийт зөрчлийн 35.8% буюу 19,108.2 сая төгрөгийг төсөвт байгууллагууд, 4% буюу 2,115.4 сая төгрөгийн зөрчлийг засгийн газрын тусгай сангууд, 16% буюу 8,800.9 сая төгрөгийг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 22% буюу 11,941.4 сая төгрөгийг төсвийн төвлөрүүлэн захирагчид, 22% буюу 11,881.6 сая төгрөгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил тус тус эзэлж байна.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил өмнөх оны дүнгээс 19,610.6 сая төгрөгөөр, үүнээс аудитын залруулга 18,327.1 сая төгрөгөөр, зөвлөмж 3,322.2 сая төгрөгөөр өсөж, төлбөрийн акт 17.9 сая төгрөгөөр, зөрчил арилгах албан шаардлага 2,004.6 сая төгрөгөөр, хариуцлага тооцох албан шаардлага 47-оор буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр хэрэгжиж эхэлсэн
2. Засгийн газрын тусгай сангуудаас олгосон зээлийг гэрээний хугацаанд төлүүлэх ажил хангалтгүй
3. Хөрөнгийн бүртгэл зөрүүтэй, тооллого хийж тооцоо бодсон акт үйлдээгүй
4. Санхүүгийн тайлангийн залруулга 18,327.7 сая төгрөгөөр өссөн нь хоорондын тооцоо нийлээгүй, нягтлан бодогч солигдсон зэрэг шалтгаантай холбоотой байна.

Дүрслэл №3: Санхүүгийн тайлангийн залруулга /сая төгрөг/



Санхүүгийн тайлангийн залруулга өмнөх оноос 2 дахин буюу 18,327.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд дийлэнх хувийг шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчид эзэлж байгаа нь санхүүгийн тайланг гаргахдаа тооцоо нийлдэггүй, санхүү бүртгэл, стандартын мэдлэг сул байгаатай холбоотой байна.

Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 106 төсвийн шууд захирагчийн тайланд аудит хийсэн бол 2023 онд 108 байгууллагад дүгнэлт гаргасан байна. Шууд захирагчдын залруулга өмнөх оноос 2,784.0 сая төгрөгөөр, албан шаардлага 918.1 сая төгрөгөөр, зөвлөмж 340.2 сая төгрөгөөр өсөж, төлбөрийн акт 402.1 сая төгрөгөөр, сахилгын хариуцлага тооцох албан тушаалтны тоо 41-өөр буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудит

Тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт 83.1 сая төгрөгөөр, зөвлөмж 59.5 сая төгрөгөөр өсөж, залруулга 3,142.0 сая төгрөгөөр, албан шаардлага 3,992.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулга 3,435.2 сая төгрөгөөр, төлбөрийн акт 90.7 сая төгрөгөөр, зөвлөмж 56.6 сая төгрөгөөр тус тус өсөж, албан шаардлага 188.7 сая төгрөгөөр буурсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар залруулга 8,866.2 сая төгрөгөөр, төлбөрийн акт 207.5 сая төгрөгөөр тус тус өсөж, албан шаардлага 57.7 сая төгрөгөөр, зөвлөмж 4.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Дараах нийтлэг зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Цалин, амралтыг давхардуулан олгож, цалингийн урьдчилгааг бүрэн суутгаагүй, авлага үүсгэхгүй орхигдуулах, үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг илүү, дутуу олгодог, дуусгалын тооцоо хийдэггүй
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, тендерт шалгараагүй компаниас худалдан авалт хийдэг, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй
- Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэгдээгүй
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийдэг, хэлбэлзэл зөрүүтэй, анхан шатны баримтгүй зарцуулалт хийдэг
- Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохирол учруулсан
- Шагнал урамшуулал, тэмцээн уралдаан, баяр ёслол тэмдэглэхэд зориулж төсвөөс үр ашиггүй зарцуулалт хийдэг
- Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлийг төлүүлэх талаар хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, арга хэмжээ аваагүй, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид шинээр зээл олгосон
- Орон нутгийн орлогыг нэр төрлөөр бүртгээгүй, төлөвлөлтийг бодитой хийдэггүй, төсвийн данснаас гадуур орлого авч зарцуулсан

- Санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа холбогдох заавар журам, стандартыг баримталдаггүй, Төрийн сан хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй


4.2. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Төрийн хэмнэлтийн тухай хууль төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад Төрийн аудитын байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахаар заасан. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ийн хүрээнд 2022 онд аймгийн байгууллагуудын хувьд эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нийт зөрчил өмнөх оноос 17 хувиар, төлбөрийн акт 98 хувиар буурч, албан шаардлага 14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл №4: ТХТХ-ын зөрчлийн харьцуулалт /сая төгрөг/



Зөрчил буурсан хэдий ч давтан гарсаар байгаа нь ажлын хариуцлага, санхүүгийн сахилга баттай холбоотой байна.

Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Дүрслэл №5: ТХТХ-ын зөрчлийг ангилж харуулбал /сая төгрөг/



Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, 15.1.6 дахь заалтуудыг зөрчиж нийт 866.8 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

4.3. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд хийж байгаа санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж тайлагнаж байхаар тусгасан.

Санхүүгийн тайлангийн аудитаар 144 байгууллагын Шилэн дансны цахим системийн 282 цэсийн хөтлөлтийг fas.audit.mn цахим системээр түүвэрлэн горим сорил хэрэгжүүлсэн.

Хүснэгт №2: Шилэн дансны тухай хуулийн зөрчлийн судалгаа


/сая төгрөг/

Зөрчлийн утга	Зөрчлийн мэдээ				Авсан арга хэмжээ /тоо/		
	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй /мөнгөн дүн/	Хугацаа хоцроосон тоо	Хугацаа хоцроосон /мөнгөн дүн/	Албан шаардлага	Зөвлөмж	хариуцлага тооцсон
ТШЗ	813	16,645.8	1,109	25,132.5	20	26	2
ТТЗ	113	1,106.8		-	1	1	-
ААТҮГ	117	1,954.0	75	5,942.7	6	3	-
ЗГТС	5	9.1	2	3.3	-	-	-
ДҮН	1,048	19,715.6	1,186	31,078.5	27	30	2

Аудитаар шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дүгээр зүйлд заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалт, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрүүд зэрэг 19,715.5 сая төгрөгийн 1048 мэдээллийг огт мэдээлээгүй, 31,078.5 сая төгрөгийн 1186 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Илэрсэн зөрчилд нийт 25 төсөв захирагчдад зөрчил арилгуулах албан шаардлага, 9 төсөв захирагчдад зөвлөмж хүргүүлсэн ба 2 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна.

Дүрслэл №6: Шилэн дансны зөрчлийн өмнөх онтой харьцуулсан судалгаа /тоо/



Эх сурвалж: Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт өмнөх онтой харьцуулахад мэдээлээгүй гүйлгээний тоо 13 хувиар буюу 146 гүйлгээгээр буурч, хугацаа хоцорч мэдээлсэн мэдээлэл 94.0 хувиар буюу 1107 мэдээллээр өссөн байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ӨГСӨН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАХГҮЙ БАЙХ ТАЛ ДЭЭР АНХААРЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

Аймгийн ИТХ-ын даргад:

- “Орон сууцны алба” ОНӨААТҮГ, “Гэгээн-нуур” ААТҮГ, Дарив Дулаан, Эрдэнэ Эрчм хүч ААТҮГ-уудын хөрөнгө, өр төлбөр, өглөг авлагыг шийдвэрлэх

Аймгийн Засаг даргад

- ✚ Орон сууцны алба” ОНӨААТҮГ, “Гэгээн-нуур” ААТҮГ, Дарив Дулаан, Эрдэнэ Эрчм хүч ААТҮГ-уудын татан буулгах үеийн хаалтын балансыг гаргаж, нэгтгэх
- ✚ Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг, Татгалзсан дүгнэлт авсан Есөнбулаг сумын ИТХ, ЗДТГ, Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, санхүүгийн албан хаагчдад Мэргэшсэн нягтлан бодогчийн институтийн Говь-Алтай салбартай хамтран зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах.
- ✚ Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэр, түүний хэрэгжилтийг хангуулж, зөрчил давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Харилцах хаяг:



**Хөгжил хороолол 1402, Жинст баг, Есөнбулаг сум,
Говь-Алтай аймаг, Монгол улс.
Утас: 7048-4030
E-mail: govialtai@audit.gov.mn**